

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/322/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер: О.Амаржаргал
Утас: 70273463. Цахим хаяг: amarjargal@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Голден пэйж Аудит" ХХК
Гүйцэтгэх захирал: С.Оюунгэрэл
Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	5
Аудитын гол асуудал.....	5
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал.....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
Завсарын аудитаар алдаа зөрчил илрээгүй.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.2 Албан шаардлага.....	
5.3 Зөвлөмж.....	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНАСАУ	Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс
СХУ	Соёл Хөгжлийн Ухаан
АБЯ	Ардын боловсролын яам



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/97

танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Ц.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангаар анхан шатны баримтаар нотлогдохгүй 41,337.7 мянган төгрөгийн гүйлгээг баримтжуулаагүй, баталгаажуулаагүй, бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа үнийн харьцуулалт хийгдээгүй, батлагдсан төсвийг 5,298.5 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тодруулга тайлан бэлтгээгүй байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д; 5 дугаар зүйлийн 5.1.4-д; 20 дугаар зүйлийн 20.2.3-д; 20.2.5-д; Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д; 50 дугаар зүйлийн 50.1-д; 50.1.1-д; 50.1.2-т заасантай нийцээгүй, УСНББОУС1-д Эрх ба үүрэг, Толилуулга, Тохиолдсон байх, Иж бүрэн байх, Нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

019020146

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолоор хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх болсноор жилийн эцэст зарцуулагдаагүй мөнгөн хөрөнгийг дараагийн жилд зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 83,228.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн боловсрол шинжлэх ухааны газрын даргаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 84,0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>124,714,606.94</u>	<u>205,589,728.40</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	6,915,782.39	83,228,851.11
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	6,915,782.39	83,228,851.11
3121	Төгрөг	6,915,782.39	83,228,851.11
31211	Төрийн сангийн харилцах	6,915,782.39	83,228,851.11
33	АВЛАГА	1,034,088.68	5,396,024.00
335	Бусад авлага	1,034,088.68	5,396,024.00
3351	Байгууллагаас авах авлага	1,034,088.68	5,396,024.00
35	БАРАА МАТЕРИАЛ	116,764,735.87	116,964,853.29
351	Түүхий эд материал	4,826,880.00	4,362,290.00
35110	Тусгай зориулалттай материал	4,076,780.00	4,076,780.00
35130	Эм боох материал	750,100.00	285,510.00
354	Хангамжийн материал	101,369,855.87	102,034,563.29
35410	Бичиг хэргийн материал	1,576,195.00	260,000.00
35420	Аж ахуйн материал	88,037,141.91	86,962,250.91
35430	Сэлбэг хэрэгсэл	274,000.00	274,000.00
35460	Хүнсний материал	2,982,058.00	00.00
35470	Бусад хангамжийн материал	8,500,460.96	14,538,312.38
35500	Биологийн хөрөнгө	5,618,000.00	5,618,000.00
35600	Мал амьтад	4,950,000.00	4,950,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,776,943,452.97</u>	<u>1,750,634,002.42</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,776,943,452.97	1,750,634,002.42
392	Биет хөрөнгө	1,590,039,452.97	1,563,730,002.42
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,666,677,160.75	1,682,374,097.75
39202	Хуримтлагдсан элэгдэл	-291,315,563.71	-357,610,399.75
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	200,695,881.35	250,148,881.35
39206	Хуримтлагдсан элэгдэл	-104,427,987.12	-125,803,240.79
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	153,895,353.00	166,771,753.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-65,009,856.45	-78,778,529.29
39214	Бусад үндсэн хөрөнгө	26,017,276.00	26,017,276.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-13,930,287.55	-16,827,312.55
39217	Ном	17,437,476.70	17,437,476.70
393	Биет бус хөрөнгө	186,904,000.00	186,904,000.00
39301	Програм хангамж	925,000.00	925,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-925,000.00	-925,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	186,904,000.00	186,904,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,901,658,059.91</u>	<u>1,956,223,730.82</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>655,262.59</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	655,262.59	00.00
413	Өглөг	655,262.59	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	655,262.59	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,901,002,797.32</u>	<u>1,956,223,730.82</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,901,002,797.32	1,956,223,730.82

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	276,988,484.54	276,988,484.54
51101	Өмч: - төрийн	276,988,484.54	276,988,484.54
512	Хуримтлагдсан үр дүн	41,124,356.45	96,345,289.95
51210	Өмнөх үеийн үр дүн	41,124,356.45	41,124,356.45
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	55,220,933.50
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,582,889,956.33	1,582,889,956.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,901,658,059.91	1,956,223,730.82

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,101,938,872.00	1,588,877,170.42
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	143,811,672.00	62,089,970.42
120	Нийтлэг татварын бус орлого	143,811,672.00	62,089,970.42
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,458,911.60	7,397,266.42
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,458,911.60	7,397,266.42
120009	Бусад орлого	00.00	9,851,767.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	263,657,700.00	1,526,787,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,309,525,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,309,525,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	694,469,500.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	116,282,200.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	116,282,200.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	147,375,500.00	217,262,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	147,375,500.00	217,262,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	960,175,473.30	1,533,376,429.07
21	УРСГАЛ ЗАРДАЛ	960,175,473.30	1,533,376,429.07
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	835,788,343.30	1,455,664,153.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	548,382,480.83	907,171,705.98
210101	Үндсэн цалин	442,385,953.80	638,622,589.84
210102	Нэмэгдэл	81,420,700.89	221,420,938.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	16,000.00
210104	Урамшуулал	24,575,826.14	47,112,178.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,673,820.30	114,605,199.82
210201	Тэтгэврийн даатгал	47,678,769.45	78,181,864.45
210202	Тэтгэмжийн даатгал	5,606,220.89	9,195,925.36
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,103,688.01	7,264,340.46

210204	Ажилгүйдлийн даатгал	1,025,922.06	1,814,775.31
210205	Эрүүл мэндийн даатгал	10,259,219.89	18,148,294.24
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,970,504.52	216,270,028.81
210301	Гэрэл, цахилгаан	10,706,504.52	19,225,836.91
210302	Түлш, халаалт	101,514,000.00	193,657,791.90
210303	Цэвэр, бохир ус	1,750,000.00	3,386,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	82,520.00	9,296,906.00
210401	Бичиг хэрэг	82,520.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	9,296,906.00
2105	Нормативт зардал	33,844,672.00	50,764,280.00
210502	Хоол, хүнс	32,911,422.00	50,764,280.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	933,250.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	180,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	180,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	00.00	6,811,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	1,899,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	4,912,400.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	70,654,345.65	149,744,133.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,895,800.00	34,052,716.55
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,755,700.00	11,355,629.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	63,002,845.65	104,335,787.55
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	124,387,130.00	77,712,275.36
2132	Бусад урсгал шилжүүлэг	124,387,130.00	77,712,275.36
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	31,740,730.00	57,368,288.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,857,800.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	62,788,600.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	20,343,987.36
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	141,763,398.70	55,500,741.35
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	279,807.85
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	00.00	279,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	00.00	807.85
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-279,807.85
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	141,763,398.70	55,220,933.50

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	958,127,200.00	1,536,720,801.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	9,933,601.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	9,933,601.00
120009	Бусад орлого	00.00	9,933,601.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	958,127,200.00	1,526,787,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	00.00	1,309,525,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	00.00	1,309,525,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	694,469,500.00	00.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	116,282,200.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	116,282,200.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	147,375,500.00	217,262,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	147,375,500.00	217,262,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	894,294,861.13	1,460,406,924.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	894,294,861.13	1,460,406,924.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	766,453,311.13	1,384,376,814.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	551,577,520.83	908,980,702.23
210101	Үндсэн цалин	389,031,803.15	592,671,229.09
210102	Нэмэгдэл	120,570,174.46	262,265,900.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	16,000.00
210104	Урамшуулал	41,975,543.22	54,027,573.14
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,673,920.30	113,306,846.50
210201	Тэтгэврийн даатгал	47,967,702.14	78,983,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,533,789.98	8,813,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,045,980.87	4,293,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,011,495.26	1,318,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,114,952.05	19,897,146.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	110,373,400.00	216,261,192.15
210301	Гэрэл, цахилгаан	7,892,200.00	16,043,480.25
210302	Түлш, халаалт	101,514,000.00	193,657,711.90
210303	Цэвэр, бохир ус	967,200.00	6,560,000.00
2105	Нормативт зардал	23,680,600.00	48,749,300.00
210502	Хоол, хүнс	23,680,600.00	48,749,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	00.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,599,900.00	7,194,600.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	1,899,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,599,900.00	5,295,100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,547,970.00	88,884,173.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,420,170.00	77,795,439.55
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,127,800.00	11,088,734.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	127,841,550.00	76,030,110.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	127,841,550.00	76,030,110.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	35,195,150.00	56,401,210.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	29,857,800.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	62,788,600.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	19,628,900.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	63,832,338.87	76,313,876.57
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	63,832,338.87	76,313,876.57
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	6,915,782.39
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	63,832,338.87	83,228,851.11

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	276,988,484.54	249,046,861.80	-112,740,551.32	413,294,795.02
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	276,988,484.54	249,046,861.80	-112,740,551.32	413,294,795.02
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-30,610,719.67	-30,610,719.67
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	276,988,484.54	1,582,889,956.33	41,124,356.45	1,901,002,797.32
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	276,988,484.54	1,582,889,956.33	41,124,356.45	1,901,002,797.32
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	55,220,933.50	55,220,933.50
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	276,988,484.54	1,582,889,956.33	96,345,289.95	1,956,223,730.82

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,542,286,100.00	1,460,406,924.43	(81,879,175.57)	94.7%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,542,286,100.00	1,460,406,924.43	(81,879,175.57)	94.7%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,454,962,600.00	1,384,376,814.43	(70,585,785.57)	95.1%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	961,765,700.00	908,980,702.23	(52,784,997.77)	94.5%
210101	Үндсэн цалин	648,871,200.00	592,671,229.09	(56,199,970.91)	91.3%
210102	Нэмэгдэл	262,011,100.00	262,265,900.00	254,800.00	100.1%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	16,000.00	16,000.00	
210104	Урамшуулал	50,883,400.00	54,027,573.14	3,144,173.14	106.2%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	120,332,300.00	113,306,846.50	(7,025,453.50)	94.2%
210201	Тэтгэврийн даатгал	81,826,000.00	78,983,500.00	(2,842,500.00)	96.5%
210202	Тэтгэмжийн даатгал	9,626,600.00	8,813,900.00	(812,700.00)	91.6%
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,701,200.00	4,293,800.00	(3,407,400.00)	55.8%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,925,400.00	1,318,500.00	(606,900.00)	68.5%
210205	Эрүүл мэндийн даатгал	19,253,100.00	19,897,146.50	644,046.50	103.3%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	216,262,000.00	216,261,192.15	(807.85)	100.0%
210301	Гэрэл, цахилгаан	16,044,100.00	16,043,480.25	(619.75)	100.0%
210302	Түлш, халаалт	193,657,900.00	193,657,711.90	(188.10)	100.0%
210303	Цэвэр, бохир ус	6,560,000.00	6,560,000.00	-	100.0%
2105	Нормативт зардал	51,720,900.00	48,749,300.00	(2,971,600.00)	94.3%
210502	Хоол, хүнс	51,720,900.00	48,749,300.00	(2,971,600.00)	94.3%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00	-	100.0%
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	-	100.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,549,600.00	7,194,600.00	(355,000.00)	95.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,899,500.00	1,899,500.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,549,600.00	5,295,100.00	(2,254,500.00)	70.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	96,443,500.00	88,884,173.55	(7,559,326.45)	92.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	85,119,200.00	77,795,439.55	(7,323,760.45)	91.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,324,300.00	11,088,734.00	(235,566.00)	97.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	87,323,500.00	76,030,110.00	(11,293,390.00)	87.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	87,323,500.00	76,030,110.00	(11,293,390.00)	87.1
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	67,694,600.00	56,401,210.00	(11,293,390.00)	83.3

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,628,900.00	19,628,900.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,557,009,501.00	1,526,787,200.00	(30,222,301.00)	98.1
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,297,781,100.00	1,307,625,700.00	9,844,600.00	100.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,297,781,100.00	1,309,525,200.00	11,744,100.00	100.9
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	241,062,000.00	217,262,000.00	(23,800,000.00)	90.1
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	241,062,000.00	217,262,000.00	(23,800,000.00)	90.1
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	18,166,401.00	1,899,500.00	(16,266,901.00)	10.5
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	6,915,782.39	6,915,782.39	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	83,228,851.11	83,228,851.11	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	51.00	51.00		
620001	Удирдах ажилтан	1.00	1.00		
620002	Гүйцэтгэх ажилтан	30.00	30.00		
620003	Үйлчлэх ажилтан	20.00	20.00		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус сургууль нь 1961 онд БНАСАУ-ын тусламж, хүч хөрөнгөөр одоогийн хичээлийн байр, дотуур байр бүхий цогцолбор ашиглалтад орж 7 жилийн дунд сургууль болж 9 бүлэг 13 багштай хичээллэж эхэлсэн байна. 1976 онд аймгийн 3 дахь 10 жилийн сургууль болон өргөжиж, МУМАБ 1972 оноос СХУ-ын хүрээлэнгийн туршилт сургууль, 1987 оноос АБЯ-ны түшиц сургууль, 1989 онд аймгийн тэргүүний сургууль болсон түүхэн уламжлалтай. Одоо тус сургууль 500 орчим суралцагсадтай 50 гаруй багш, ажилтан албан хаагчидтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Алтанбулаг сумын сургууль нь бага, суурь, бүрэн дунд боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Сургууль нь сургалт, үйл ажиллагааны орчинд суралцагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, мэдлэг чадвар авьяасаа хөгжүүлэх, төлөвшихөд дэмжлэг үзүүлэх, хүүхдийн хөгжил, төлөвшил, сурах үйл явцын талаар эцэг эх асран хамгаалагч, дэмжигчтэй хамтран ажиллах чиг үүргийг гүйцэтгэнэ.

Тус байгууллага нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, үнэлгээ арга зүй, технологи, суралцагчийн эрх, хамгаалал, хөгжил, төлөвшил, тэгш хамран сургалт, ажил мэргэжлийн баримжаа, багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжил, удирдах ажилтныг мэргэжил арга зүйгээр хангах, зөвлөн туслах олон нийтийг энэ чиглэлийн мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлж ажиллах, холбогдох талуудын түншлэлийн үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр төлөвлөн гүйцэтгэлийг ханган ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Боловсролын ерөнхий хууль шинэчилсэн найруулга
- ✓ Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль
- ✓ Зөвшөөрлийн тухай хууль
- ✓ Багшийн хөгжлийг дэмжих тухай
- ✓ Хөрөнгийн үнэлгээний тухай хууль
- ✓ Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, түүнд хамрах албан тушаалын жагсаалтад өөрчлөлт орсон.
- ✓ Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор цалингийн доод хэмжээг тогтоосон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 01 дугаар сарын 24-ны өдрийн А/02 дугаар тушаалаар батлагдсан Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллагуудад мөрдөх “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” байна.

Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн бөгөөд тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 54,565.6 мянган төгрөгөөр буюу 2,9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,915.8	83,228.9	76,313.1
Авлага	1,034.1	5,396.0	4,361.9
Бараа материал	116,764.7	116,964.8	200.1
Үндсэн хөрөнгө	1,776,943.5	1,750,634.0	(26,309.5)
Нийт хөрөнгө	1,901,658.1	1,956,223.7	54,565.6
Өр төлбөр	655.3		(655.3)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	276,988.5	276,988.5	
Хуримтлагдсан үр дүн	41,124.4	96,345.3	55,220.9
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,582.889.9	1,582.889.9	
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,901,658.1	1,956,223.7	54,565.6

Хүснэгтээс харахад 2023 оны үзүүлэлтээс нөлөө бүхий дараах өөрчлөлтүүд гарсан байна.

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 76,313.1 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвөөс хүлээн авсан санхүүжилтийн зарцуулаагүй үлдэгдэл буцаан төвлөрүүлээгүй нь гол нөлөө үзүүлсэн байна.
- Авлагын үлдэгдэл өмнөх оныхоос 4,361.9 мянган төгрөгөөр өссөн цахим анги байгуулах төсөл хөтөлбөр байгуулах тоног төхөөрөмж худалдан авахтай холбоотой.
- Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 200.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 140,153.9 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан 7,397.3 мянган төгрөг нийт 147,551.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 147,351.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан нь гол нөлөө үзүүлсэн байна.
- Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 26,309.5 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 33,185.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, үнэ төлбөргүй 44,840.9 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө нэмэгдэж, нийт 78,026.3 мянган төгрөгөөр өсөж, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 104,335.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөсөн байна.
- Өглөг тайлант хугацаанд 655.3 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны өр төлбөрийг барагдуулсан нь нөлөө үзүүлсэн байна.
- Засгийн газрын хувь оролцоо нь тайлант оны үр дүн 54,565.6 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвийн болон орон нутгийн төсвийн санхүүжилтэд гол нөлөөлөл үзүүлсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,331,939.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,331,939.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж 2022 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 05 албан тоотой дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 6,915.8 мянган төгрөгөөр бууруулж, 1,325,024.1 мянган төгрөгөөр баталсан байгаа нь шалгагдагч байгууллагын хүргүүлсэн саналын үндэслэлийг харгалзан баталдаггүйгээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 81,879.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн мэргэжлийн боловсролын-71801 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,325,024.1 мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,325,024.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,243,145.7 мянган төгрөг буюу 92,1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны нэмэгдэл цалин, нормативд зардал, бусад урсгал шилжүүлэг бусад зардлуудаас 81,879.2 мянган төгрөг хэмнэсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1.1	Байр ашиглалтын үйлчилгээ-80226	216,262.0	216.261.2		

1.2	Сургалт -80312	1,082,098.0	1,022,287.5	59,105.0	94,5
1.3	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг-81801	87,323.5	76,030.1	11,293.4	87,1
1.4	Дотуур байрны үйлчилгээ-81806	86,007.8	78,795.5	7,212.3	90,2
1.5	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин-81816	51,720.9	48,749.3	2,971.6	94,3
1.6	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх-81823	7,549.6	7,194.6	355.0	95,3
1.7	Сургалтын хэвийн үйл ажиллагаа-81835	11,324.3	11,088.7	235.6	97,9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тус байгууллага нь 2023 онд худалдан авах ажиллагаагаар норматив зардал 48,749.3 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний зардал 88,884.1 мянган төгрөгөөр худалдан авалт хийхдээ Засаг даргын тамгын газраас нэгдсэн журмаар тендер сонгон шалгаруулалт хийдэг, нэгдсэн гэрээтэй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ын аудитор Я.Оюун, шинжээч Д.Энх-амгалан, Ө.Бат-оюун нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ын аудитор Я.Оюун, шинжээч Д.Энх-амгалан, Ө.Бат-оюун нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Алтанбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 05 тоот дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн байдлын тайлангийн 1,665,174.9 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 24,977.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 18,733.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь үндсэн ба нэмэгдэл цалин 108,984.8 мянган төгрөг, нормативт зардал 2,971.6 мянган төгрөг, мэдээлэл технологийн үйлчилгээ 2,254.5 мянган төгрөг, бараа ажил үйлчилгээний бусад зардал 7,559.3 мянган төгрөгөөр хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

4.4.1.1 Тайлант хугацаанд шилэн дансанд нийт мэдээлэх 159 мэдээллээс 152 мэдээллийг хугацаанд нь байршуулж, хугацаа хоцорсон 2 мэдээлэл, 5 мэдээлэл байршуулаагүй, шилэн дансанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагыг өссөн дүнгээр 54,122.6 мянган төгрөг дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6 дугаар зүйлийн 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн

гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1 Улсын бүртгэлийн гэрчилгээ дээр хөрөнгийн хэмжээ 141,669.5 мянган төгрөг, санхүү байдлын тайлан дээр төрийн өмч 276,988.5 мянган төгрөг 135,318.8 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь хөрөнгө өр төлбөр болон өмчийн хувь оролцоог зөв дүнгээр тусгасан ба үнэлгээ болон хуваарилалтын залруулга, холбогдох тодруулгыг зохих ёсоор хэмжсэн тайлбарласан байх “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Мэдээллийг үнэн зөв баталгаажуулах, бүртгэлдээ өөрчлөлт хийх зөвлөмж хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Засварын аудитаар 6 алдаа зөрчил илрүүлэн танилцуулсан боловч, алдаа зөрчлийг арилгах арга хэмжээ аваагүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар санхүүгийн тайланд илрүүлсэн 162.0 мянган төгрөгийн 1 акт, 1 зөвлөмжийг 50 хувьтай хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	162.0	1	162.0	100
Зөвлөмж	1		0	0	0
Нийт дүн	2	162.0	1	162.0	50

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал төсөв, санхүүжилтийг үндэслэлтэй баталдаг байх, шинэчлэлийн бодлого, төрийн чиг үүргийг хангалттай хэрэгжүүлэн ажиллаж байгаа талаар анхаарал хандуулах болно. Сургуулийн үндсэн хөрөнгө болон газар эзэмших эрхтэй холбоотой асуудлыг хянаж үзэх, газрын ашиглалт, баталгаажуулалт, сайжруулалт, төлбөр төлөлтийн талаар дараагийн аудитаар авч үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 41,331.7 мянган төгрөгийн 3 зөрчил илэрснээс, 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлээ.

5.2 Албан шаардлага

5.2.1 Мөнгөн хөрөнгийн түүврийн горим сорил хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны зарцуулалт гаргах, бараа түүхий эд, материал худалдан авахдаа анхан шатны цахим баримт 41,331.7 мянган төгрөгөөр илүү бүртгэсэн, гэрээгүй баримтжуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь. МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй”; 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн 121 нэр төрлийн 142,183.5 мянган төгрөгийн хөрөнгө үлдэх өртөггүй өртгөө нөхсөн байгаа нь хөрөнгийн бүртгэлийг бодит үнэ цэнээр бүртгэж тайлагнаагүй, тооллого тооцооны үр дүнг хэлэлцээгүй, чанар байдлыг тодорхойлоогүй, ашиглалтын шаардлага хангахгүй хөрөнгийн жагсаалт, мэдээллийг тодруулга тайлан бэлтгэж тайлагнаагүй байгаа нь СТОУС-13 стандартын 6.12-д “Бодит үнэ цэнэ гэж зах зээлд оролцогчдын хоорондох цэгцтэй ажил гүйлгээгээр хэмжилтийн өдөр хөрөнгийг борлуулснаар хүлээн авах эсвэл өр төлбөрийг барагдуулснаар төлөх үнийн дүн юм”, 6.13-д “Бодит үнэ цэнд зах зээлд оролцогчид буюу тухайн аж ахуйн нэгж нэвтрэх боломжтой зах зээлд оролцогчдын хэтийн төлөв тусгагддаг. Эдийн засгийн ашиг тусын төлөө хамгийн сайн үйл ажиллагаа эрхэлдэг бол хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтооходоо тэдний ашиглаж болох ижил төстэй таамаглалыг ашиглан, тэдгээр хөрөнгө өр төлбөрийг хэмждэг” гэсэнтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн бүртгэлийг бодит үнэ цэнээр бүртгэж, тайлагнадаг байх зөвлөмж хүргүүлэв.

2. Бичиг хэрэг хөтлөлтийн талаар

Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
159 мэдээллээс 152 мэдээллийг хугацаанд нь байршуулж, хугацаа хоцорсон 2 мэдээлэл, мэдээлэлгүй 5 мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний мэдээлэл оруулаагүй	1	54,122.6			1	54,122.6		
Дүн	1				1	54,122.6		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Улсын бүртгэлийн хөрөнгийн хэмжээ, санхүүгийн тайлангийн засгийн газрын оролцооны дүнгээс зөрүүтэй	1	135,318.8					1	135,318.8
Дүн	1	135,318.8					1	135,318.8
Нийт дүн	2	189,441.4			1	54,122.6	1	135,318.8



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 12 өдөр

Дугаар АИ-14510516-ТӨА-2024/

Зуунмод

300/10А-СТА-ТМС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 54,122,600 /тавин дөрвөн сая нэг зуун хорин хоёр мянган зургаан зуун/ төгрөг өссөн дүнгээр дутуу мэдээлсэн, хугацаа хоцорсон 2 мэдээлэл, 5 мэдээлэл байршуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3."тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;", 6 дугаар зүйлийн 6.4."Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:", 6.4.4."таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"; 6.4.5."цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-д "хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны мэдээллийн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт³ ирүүлэх;

³Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040098

2. Цаашид алдаа², зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ц.Бат-Эрдэнэ, нягтлан бодогч Ш.Гантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

A black ink handwritten signature, appearing to be 'С.Оюунгэрэл', written in a cursive style.

/С.ОЮУНГЭРЭЛ/

²Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582



ТӨВ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 1д өдөр

Дугаар 20-1451/0516-ТӨА-2024

Зуунмод

З.А.НА-СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар анхан шатны цахим баримт 41,331,700 /дөчин нэгэн сая гурван зуун гучин нэгэн мянга долоон зуун/ төгрөгөөр илүү бүртгэсэн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль, тогтоомж, гэрээ хэлэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цахим төлбөрийн баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээ хийсэн зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024.6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэх;

¹Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582

019040094

2. Цаашид алдаа², зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Алтанбулаг сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Ц.Бат-Эрдэнэ, нягтлан бодогч Ш.Гантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



/Ц.ХИШИГЖАРГАЛ/

ГОЛДЕН ПЭЙЖ АУДИТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

A handwritten signature in black ink, appearing to be "С.Оюунгэрэл".

/С.ОЮУНГЭРЭЛ/

²Төв аймаг, Зуунмод сум, 6 дугаар байр, Төр захиргааны 2 дугаар байр 105 тоот Утас: 70272582